

ХАСБАНК ХК (“ХАСБАНК” ЭСХҮЛ “БАНК”)-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ДАВАА ГАРАГИЙН 09:00-11:30 (УЛААНБААТАРЫН ЦАГААР) ЦАГИЙН ХООРОНД МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, ШАНГРИ-ЛА ЗОЧИД БУУДАЛ, ИХ ТАНХИМД ХУРАЛДСАН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ОГНОО БА ХУРАЛДСАН ГАЗАР

Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“ХЭЭХ”) 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн Даваа гарагийн 9.00-11:30 цагийн /Улаанбаатарын цагаар/ хооронд Монгол Улс, Улаанбаатар хот, Шангри-Ла Буудал, Их танхимд хуралдав. Хурал танхим болон цахим хосолсон байдлаар зохион байгуулагдав.

ХЭЭХ-ыг монгол хэлээр хөтлөн явуулж, илтгэлүүдийг мөн монгол хэлээр тавьсан бөгөөд хурлын дарга Санжай Гүптагийн англи хэл дээр илтгэсэн нээлтийн үг болон бусад яриаг орчуулагчийн тусламжтайгаар монгол хэл дээр шууд хөрвүүлэн хүргэв.

1. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ИРЦ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу, ХЭЭХ-д энгийн олонх оролцсоноор буюу Компанийн нийт энгийн хувьцааны 50%+1 хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсоноор хурал хүчин төгөлдөр болохыг тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга, Кэй И Партнерс ХХН-ийн Гүйцэтгэх захирал Б.Ананд, Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-20 дугаар тогтоолоор банкны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарласныг дурдаад, ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд ашиглаж буй ХасMeeting аппликейшнд хөндлөнгийн аудитыг Си И Ти Эй ХХК хийсэн ба ITAF, GTAG, ISA315, ISA330 олон улсын стандарт, зааварчилгааг хангасан, үнэн зөв, бүрэн бүтэн тооцоолдог болохыг баталгаажуулсан гэж тэмдэглэв.

Тооллогын комиссын дарга Банкны гаргасан нийт 1,052,700,000 (нэг тэрбум тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ХЭЭХ-д 1,009,365,317 (нэг тэрбум есөн сая гурван зуун жаран таван мянга гурван зуун арван долоо) ширхэг энгийн хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсон тул хурлын ирц 95.88% (ерэн тав зууны наян найм)-иар бүрдсэнийг зарлав.

Ийнхүү, Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болсныг мэдэгдэв.

ХЭЭХ-д дараах бусад оролцогчид оролцов:

ТУЗ-ийн гишүүд

1	Санжай Гүпта	ХасБанкны ТУЗ-ийн дарга
2	Г.Цэвэгжав	ХасБанкны Гүйцэтгэх захирал ба ТУЗ-ийн гишүүн (“Гүйцэтгэх захирал”)
3	Б.Уламбаяр	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
4	Нираж Вэдва	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
5	Эми Чой	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
6	Майкл Мадден	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
7	Анджей Витак	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн
8	Сюзанна Карр	ХасБанкны ТУЗ-ийн гишүүн

Гүйцэтгэх удирдлага

1	Г.Эрдэнэбаяр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал
2	Э.Уламбаяр	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал

3	Б.Еркин	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал
4	С. Дауренбек	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал
5	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал
6	Г.Зул	Үйл ажиллагаа хариуцсан захирал
7	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал
8	Н.Мөнхцэлмэг	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Хууль хариуцсан захирал ("ХХЗ/ТУЗНБД")
Тооллогын комисс		
1	Б.Ананд	Кэй И Партнерс ХХН-ийн Гүйцэтгэх захирал
2	М.Лхамсүрэн	Кэй И Партнерс ХХН-ийн Партнер
3	Г.Хажидмаа	Кэй И Партнерс ХХН-ийн Туслах хуульч

ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүд болох Б.Уламбаяр, Нираж Вэдва болон Эми Чой нар нь Хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар биечлэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцов.

2. ХУРЛЫН НЭЭЛТ

Банкны Дүрмийн 8.9 дэх хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн дарга Санжай Гүпта ("Хурлын дарга") ХЭЭХ-ыг даргалав.

Хурлын дарга ХасБанк ХК-ийн ХЭЭХ-д оролцож буй нийт хувьцаа эзэмшигчиддээ талархал илэрхийлээд нээлтийн үг хэлэв:

"ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн анхдугаар ээлжит хуралдаанд оролцож буй хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. ХасБанкны түүхэнд 2023 он олон шалтгааны улмаас онцгой жил боллоо. Эн тэргүүнд одоогоос 10 сарын өмнө буюу 2023 оны 6 дугаар сард Банк анх удаа олон нийтэд хувьцаагаа санал болгож нээлттэй хувьцаат компани болсон. Арван мянга орчим иргэн, аж ахуйн нэгж ХасБанкны хувьцааг авах сонголт хийснээр IPO амжилттай болсон билээ. Нээлттэй хувьцаат компани болсон нь бидний хувьд том хариуцлага болохыг бүрэн ухамсарлаж байгаа бөгөөд энэхүү хариуцлагыг хүлээхийн төлөө цаашид ч улам хичээл зүтгэлтэй шаргуу ажиллах болно. Дараагийн онцлууштай үйл явдал бол 2023 онд татварын дараах цэвэр ашгийг 142 тэрбум хүргэж, өмнөх оноос 34.2%-иар өсгөсөн. Ингэснээр бид IPO хийх үед танилцуулж байсан санхүүгийн төсөөллөөсөө бүтэн нэг жилээр түрүүлж алхаж байна. Зөвхөн ашигт ажиллагаатай бизнесийн байгууллага улс, нийгэмдээ сайн сайхан зүйл хийж бүтээхэд дэмжлэг үзүүлж чаддаг. Ийнхүү 2023 онд бид улсын болон нийслэл, орон нутгийн төсөвт 100 орчим тэрбум төгрөгийн татвар, шимтгэл төвлөрүүлэн өөрийн хувь нэмрийг оруулсан.

Банкны тулгуур багана болох өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зээлийн чанар, эрсдэлийн нөөц зэргийг маш найдвартай баттай хэмжээнд байлгаж чадсанаар банк ашигтай ажиллаж, улмаар тогтвортой өсөлтөд хүрч чадна гэдэгт бид итгэдэг. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ 20.7% байгаа нь салбартаа тэргүүлж байна. Өөрийн хөрөнгийн өгөөж 26.3% байгаа бөгөөд чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт банкны системд хамгийн сайн буюу нийт зээлийн 2.9% байна.

Банк нь 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 14.75 төгрөгийн ногдол ашиг хуваарилсан. Өнөөдрийн хурлаар 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 25.25 төгрөгийн ногдол ашиг тараах асуудлыг хэлэлцэх гэж байна.

Та бүхний мэдэж байгаачлан, ХасБанкны хувь эзэмшилд эцсийн өмчлөгчийн хувьд нэг хувьцаа эзэмшигч дангаараа 20%-иас дээш хувийг эзэмшдэггүй бөгөөд ингэснээрээ Банкны шийдвэр гаргалтад та бүхний эрх ашгийг хамгаалж байдаг билээ.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь ХасБанк ХК-ийн 94.99%-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд олон улсын болон дотоодын нэр хүнд бүхий банк, санхүүгийн байгууллагууд болон компаниуд зэрэг 10 хувьцаа эзэмшигчтэй. Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсгийг хангах зорилгоор бид ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанк ХК-д нэгтгэх асуудлыг өнөөдөр хэлэлцэж, та бүхний санал хураалт болон холбогдох зохицуулагч байгууллагуудын зөвшөөрснөөр ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн хувьцаа эзэмшигчдийг шууд ХасБанкны хувьцаа эзэмшигч болгож, Банкны тухай хуулийг хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Хоёр компанийг нэгтгэх асуудалтай холбоотойгоор та бүхний асуултад хариулахаар холбогдох мэргэжлийн байгууллагууд хүрэлцэн ирсэн байгаа.

Бидний хувьд Үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу хоёр компанийг нэгтгэж байгаа зорилго нь нэн тэргүүнд Банкны тухай хуулийн шаардлагыг биелүүлэхэд оршиж байгаа ч, нөгөө талаасаа бүх хувьцаа эзэмшигчдийг ижил түвшинд байлгаж, ингэснээрээ хувьцаа эзэмшигчдийн хурал илүү нээлттэй болно гэж үзэж байна.

ХасБанкны ил тод байдал, засаглалыг улам өндөр түвшинд хүргэх нь бүх хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцэж байгаа гэдэгт итгэлтэй байна. Хэрэв өнөөдрийн хурлаар хувьцаа эзэмшигчид та бүхэн тус хоёр компанийг нэгтгэх асуудлыг хэлэлцэж дэмжсэн шийдвэр гаргасан тохиолдолд бид хэрэгжүүлэх ажлыг аль болох цаг алдалгүй шуурхай гүйцэтгэх болно.

Бид 2024 оныг мөн сайн эхлүүлж чадлаа. Эхний улирлын цэвэр ашиг 42 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 35%-иар өссөн үзүүлэлт юм. Өөрийн хөрөнгийн өгөөж 26%, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт 21%, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 38%, чанаргүй зээлийн харьцаа 2.6% байна. Бусад санхүүгийн үзүүлэлтүүд ч мөн сайн байна.

Эцэст нь ХасБанкиндаа чин сэтгэлээ зориулж ажилладаг бүх ажиллагсдадаа талархал илэрхийлье. Бас Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавын чадварлаг манлайлал, аливаа бэрхшээл, сорилтуудыг даван гарахад зөв чиглүүлж чаддаг Удирдлагын багтаа баярлалаа гэж хэлмээр байна. Мөн энэ завшааныг ашиглан зөв чиглэлээр хангаж ажилласан ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлье.

Бид сүүлийн таван жилд сайн ажилласан ч хамгийн чухал нь Банкныхаа тулгуур баганыг бэхжүүлж, цаашдын хөгжилд зөв чигээр алхаж байна. Бид оргилдоо хараахан ирээгүй гэдэгт би итгэлтэй байна. Бид хамтдаа илүү өндөр оргилд хүрч чадна, хүрэх ч ёстой гэж итгэж байна.”

3. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав ХасБанкны ХЭЭХ-д хүрэлцэн ирсэн хүн бүрийг халуун дотноор угтан авч талархлаа илэрхийлээд, хувьцаа эзэмшигчдэд ХЭЭХ-ын дэгийг танилцуулав. Мөн хурлыг хосолсон хэлбэрээр зохион байгуулж буйг онцлоод, Тооллогын комиссын гишүүдийг танилцуулав.

4. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

Гүйцэтгэх захирал ХЭЭХ-ын хэлэлцэх асуудлыг ТУЗ-өөс баталж, нийт хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу урьдчилан танилцуулсан гэдгийг дурдав.

Хурлын хэлэлцэх асуудлыг хувьцаа эзэмшигчдэд дараах байдлаар танилцуулав:

Танилцуулах асуудал:

1. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тайлан.

Шийдвэрлэх асуудал:

1. ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
2. ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай;
3. ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
5. Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай;
6. ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай – Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу;
7. ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай – Банкны хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн оруулсан саналын дагуу;
8. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай;
9. Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай;
10. ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай; мөн
11. ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай.

5. ХАСБАНКНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- **Үйл ажиллагааны онцлох үйл явдал**

Гүйцэтгэх захирал Банк тайлант хугацаанд нээлттэй хувьцаат компани болсон, 205 сая ам.долларын эх үүсвэр татвар төвлөрүүлсэн, ТОП-100 ААН-ийн нэгээр шалгарсан болон Оюу Толгой ХХК-тай Тэтгэвэр/хуримтлалын сан үйлчилгээний гэрээ байгуулж хамтран ажиллаж эхэлсэн бөгөөд өөр бусад компаниудад энэхүү үйлчилгээг үзүүлж буй талаар үйл ажиллагааны онцлох үйл явдлуудыг танилцуулав.

Тэрээр үргэлжлүүлэн Банк нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчлөн байгуулснаас хойш хувьцаа эзэмшигчдийн оролцоог ил тодоор хангасан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус анхдугаар хурлыг амжилттай зохион байгуулж, Банкны Дүрмийг баталсныг тэмдэглэв.

Тэрээр Moody's агентлагаас тайландаа ирэх 12-18 сарын хугацаанд ХасБанкны зээлжих зэрэглэлийн “В3/тогтвортой” үнэлгээг хэвээр үлдээсэн талаар дурдав.

Мөн онлайн хадгаламж, орон сууцны зээл, Амар зээл, урт хугацааны Уртааар зээл, онлайн цалингийн зээл, ХАА-н салбарыг дэмжих зээлийн хөтөлбөр зэрэг шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн талаар танилцуулав.

Түүнчлэн барьцааны хөнгөлөлттэй, бичил ЖДБ-ийн зээлээс бага хүүтэй эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих бизнесийн зээлийг зах зээлд амжилттай нэвтрүүлж нийт 329.7 тэрбум төгрөгийн зээл олгосон талаар онцлон, цахим хэрэглэгчдийн тоо 31.3%, пос терминалын тоо 36%, мөн нийт гүйлгээний тоо 11.4%-иар тус тус нэмэгдсэн болохыг тэмдэглэв.

Гүйцэтгэх захирал Банкны тогтвортой хөгжил болон ногоон санхүүжилтын санаачилгын хүрээнд гаргасан ололт амжилтыг онцлов. ХасБанк нь НҮБ-ын Уур амьсгалын ногоон сантай Магадлан итгэмжлэлийн мастер гэрээ байгуулж магадлан итгэмжлэлийн эрхээ сунгаж, 8 сая ам.долларын эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн. Мөн “Ногоон зээлийн өдөрлөг”-ийг амжилттай зохион байгуулж, Тогтвортой санхүүжилтийн бодлогыг хэрэгжүүлэхэд салбартаа манлайлан 2023 оны “Онцлох ToC байгууллага”-аар шагнагдсан тухай тэмдэглэв.

Хүний нөөцийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд ХасБанк үүсгэн байгуулагдсан цагаасаа “Жендерийн тэгш байдлын бодлого”-ыг хэрэгжүүлж, байгууллагын зөв соёл, сайн засаглалыг хөгжүүлэн бэхжүүлж, шударга тогтвортой хөдөлмөрийн харилцааг үүсгэхийг зорин ажиллаж ирсэн болохыг дурдав.

- **Санхүүгийн үзүүлэлт**

Гүйцэтгэх захирал 2023 оны санхүүгийн гол үзүүлэлтүүдийг онцлон танилцуулав. Үүнээс, цэвэр ашиг 142.1 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны 105.8 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас даруй 34.2%-ийн өсөлттэйгээр Үнэт цаасны танилцуулгад тусгасан зорилтыг давуулан биелүүлсэн байна. Мөн балансын бүтэц болон ашигт ажиллагаа сайжирч, Банкны нийт актив 5 их наяд төгрөгийг давж оны эхнээс 30.2%-иар өссөн амжилттай ажилласан байна.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн санхүүгийн өөр бусад үзүүлэлтүүд болох өөрийн хөрөнгийн өгөөж (ROE), зээл, санхүүгийн түрээсийн багц, харилцах, хадгаламж, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтүүдийн талаар танилцуулав.

Банкны зээлийн үйл ажиллагаа нь Иргэдийн банк, Байгууллагын банк болон Хаслизинг (Санхүүгийн түрээс) гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг бөгөөд тэдгээрийн талаар товч танилцуулав.

Тэрээр Банкны нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 33.9% өссөнтэй зэрэгцээд активын чанараа сайн хэвээр хадгалан ажилласны үр дүнд нийт багцад эзлэх чанаргүй зээлийн харьцаа үзүүлэлт өмнөх оноос 1.1 нэгж хувиар буурч 2.9%-д хүрсэн болохыг онцлон тэмдэглэв.

Гүйцэтгэх захирал үргэлжлүүлэн харилцах хадгаламж, гадаад эх үүсвэр, зээлжих зэрэглэл зэрэглэл гол үзүүлэлтүүдийг онцлон Банкны санхүүгийн үзүүлэлтүүд тогтвортой байгааг тэмдэглэв.

- **Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт**

Гүйцэтгэх захирал Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хүрээнд дараах гурван үзүүлэлтийг тоймлон хүргэв:

Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт: Монголбанкнаас банкуудад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтийн доод хязгаарыг 9%-иар тогтоосон байдаг. Мөн системийн нөлөө бүхий банкуудад нөөц интервалын шаардлага 3-4% хүртэл нэмж тогтоодог. ХасБанк нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлтээ 2023 оны тайлант хугацаанд 20.7% буюу байвал зохих хэмжээнээс 8.2 нэгж хувиар давуулан хангаж ажилласан. Ийнхүү тус үзүүлэлтийг давуулан хангаж буй нь ХасБанкны аливаа болзошгүй эрсдэлийг хүлээх чадвар тэр хэмжээгээр ахиу болох, ирээдүйн зээлийн өсөлтийг хангах болон ногдол ашиг хуваарилах боломжтойг илтгэж байна.

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлт: Монголбанкнаас арилжааны банкуудад төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг 25%-иар тогтоосон байдаг. ХасБанк нь өөрийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд түргэн борлогдох актив хөрөнгийг бэлэн мөнгө эсхүл хамгийн бага эрсдэлтэйд тооцогдох хэрэгсэлд байршуулан удирдаж байгаа бөгөөд 2023 оны байдлаар тус харьцаа үзүүлэлтийг 37.9% буюу Үнэт цаасны танилцуулгад тусгасан зорилтоос давуулан хангасан. Банкны зээлийн багцыг нэмэхээр төвлөрч, хөрөнгийг түргэн борлогдох актив дээр байршуулан ажилласан учраас энэхүү харьцаа үзүүлэлт буурч харагдаж буйг онцлов.

Бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд: Гүйцэтгэх захирал Монголбанкнаас тогтоосон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг Банк хангаж ажилласныг онцлоод, аль нэг салбар эсхүл активт төвлөрөх төвлөрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор багцыг төрөлжүүлсэн болохыг танилцуулав.

- **Сангаас хаасан зээлийн тайлан**

Гүйцэтгэх захирал 2023 оны 11 дүгээр сарын ТУЗ-ийн хурлаар сангаас хаах зээлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэсэн талаар хувьцаа эзэмшигчдэд тайлбарлаж, тухайн сангаас хаасан зээлүүд нь Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайдын хамтарсан тушаалаар баталсан Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журмын шаардлагыг бүрэн хангасан болохыг тэмдэглэв. Мөн Банк нь зээлийг сангаас хаасан эсэхээс үл хамаарч өр төлүүлэх ажиллагааг хэвийн үргэлжлүүлж ажиллаж байна.

Тэрээр сангаас хаасан зээлийг бүтээгдэхүүн болон үндэслэлээр ангилан танилцуулж, ЖДБ-ийн, орон сууцны, хэрэглээний, санхүүгийн түрээсийн зээлийн бүтээгдэхүүнд нийт 3,994 сая төгрөгийн үнийн дүн бүхий 172 зээлийг сангаас хаасан болохыг тэмдэглэв.

Гүйцэтгэх захирал цааш нь засаглалын тайлан танилцуулж, түүний хүрээнд ТУЗ-ийн хуралдсан хуралдаан болон шинээр баталсан бодлого, журмуудыг товч танилцуулав.

Танилцуулгын дараагаар гүйцэтгэх захирлын сануулж, ТУЗ-ийн даргын урьснаар, хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацаагаар хүлээсний эцэст хэлэлцэх дараагийн асуудалд оров.

6. ХАСБАНКНЫ 2023 ОНЫ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргээд дараах илтгэлийг тавив:

Банкны тухай хуулийн дагуу ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдэдээ болон олон нийтэд хуулийн хугацаандаа багтааж 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдөр бүрэн эхээр нь нээлттэй толилуулсан байгаа.

2023 онд Эрснт энд Янг Монголиа Аудит ХХК нь хуулийн дагуу ХасБанкны хараат бус аудитороор сонгогдон ажилласан бөгөөд ХасБанкны санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандарт, дүрэм журмын дагуу хяналт хийж, удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь НББОУС болон СТОУС-ийн дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн.

Аудитлагдсан тайлангийн 4-8 дахь хуудаст буй хараат бус аудиторын дүгнэлттэй танилцах боломжтой. Мөн аудитлагдсан тайлан нь санхүүгийн үндсэн дөрвөн тайлангаас гадна нэмэлт 34 тодруулгатай, нийт 92 хуудас тайлан бөгөөд монгол болон англи хэлээр үйлдэж нийтэлсэн болно. Мөн аудитлагдсан санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүдийн талаар товч танилцуулав.

Компанийн тухай хуулийн дагуу ХасБанкны Аудитлагдсан тайланг ТУЗ хэлэлцэж **“ХасБанкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ийн дагуу үнэн зөв бодитоор тайлагнасан байна”** гэж дүгнэсэн болохыг 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулсан бөгөөд дүгнэлтийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд ийнхүү танилцуулж байна гэв. Тэрээр танилцуулгаа дуусгаад асуулт хариултын цагийг нээв.

Хурлын дарга хувьцаа эзэмшигчдийг асуулт асуухыг уриад Эрснт энд Янг Монголиа Аудит ХХК-ийн ахлах партнер энэхүү хуралд оролцон, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар хүрэлцэн ирснийг тэмдэглэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

7. ХАСБАНКНЫ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН БОЛОН АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Хурлын дарга ХасБанкны ТУЗ нь Банкны 2023 оны үйл ажиллагааны тайланг сайтар хянан үзсэний үндсэнд, тус тайлан нь ХасБанкны үйл ажиллагааны үр дүнг үнэн зөв бөгөөд бодитоор илэрхийлсэн гэж 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-12 дугаар тогтоолоороо дүгнэсэн болохыг тэмдэглэв.

Хурлын дарга үргэлжлүүлэн Банкны 2023 оны санхүүгийн тайланг Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК, дэлхийн 4 том аудитын компанийн нэг хянаад зөрчилгүй гэж дүгнэсэн болохыг дурдав. Тэрээр тус аудитлагдсан тайланг Аудитын хороо нарийвчлан хянасны дараагаар ТУЗ 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2024-19 дүгээр тогтоолоороо ХасБанкны санхүүгийн байдлыг СТОУС болон НББОУС-ын дагуу үнэн зөв бөгөөд бодитоор тайлагнасан гэж дүгнэсэн болохыг тэмдэглэв.

Хурлын дарга Компанийн тухай хуулийн 62.1.9 дэх заалтын дагуу Банкны 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг тус тус батлахыг хувьцаа эзэмшигчдээс хүсэв.

Танилцуулгын дараагаар хурлын дэгийн дагуу, ТУЗ-ийн даргын зарласнаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

8. ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН ТАЙЛАН

Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн Б.Уламбаяр ХЭЭХ-д оролцож хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрийн өмнөөс тайланг дараах байдлаар танилцуулав:

“ХасБанк 2023 онд санхүүгийн хувьд гайхалтай үр дүнд хүрсэн. Татварын дараах цэвэр ашиг 142 тэрбум төгрөгт хүрч, түүхэн дээд амжилт тогтоосон байна. Санхүүгийн бүх гол үзүүлэлтүүд нь өнгөрсөн оны үнэт цаасны танилцуулгад тусгасан төлөвлөгөөт тоонуудыг давсан байна. Энэхүү онцгой үр дүн үзүүлэхийн зэрэгцээ, чанаргүй зээлийн харьцааг салбартаа тэргүүлэхүйц бага түвшинд байлгаж, жилийн эцсийн байдлаар 2.9% болгосон. Мөн ХасБанк 2023 онд олон нийтэд хувьцаагаа амжилттай арилжаалж хувьцаагаа олон нийтэд санал болгосон нь онцлох үйл явдал болсон. Энэхүү гайхалтай гүйцэтгэлд ТУЗ-ийн хараат бус гишүүдийн зүгээс Гүйцэтгэх захирал болон удирдлагын баг хамт олонд талархаж байна.

Түүнчлэн, Банк нь дижитал технологид үргэлжлүүлэн хөрөнгө оруулж, харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэн, шинэлэг бүтээгдэхүүнээ хүргэхийг зорьж ажиллаж байгааг тэмдэглэмээр байна. ТУЗ саяхан банкны стратегийг хэлэлцэх зорилтот уулзалт зохион байгуулж, үндсэн үзүүлэлтүүдээр цаашид үргэлжлүүлэн өсөхөд шаардлагатай урт болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөг ярилцлаа.

Банк 2023 оны эхний хагас жилд 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан ба удирдлагын зүгээс 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас 26.6 тэрбум төгрөгийг ногдол ашиг болгон хуваарилах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн өнөөдрийн хурлаар эцэслэн шийдвэрлүүлэх гэж байна. Ийнхүү ХасБанк 2023 оны хувьд нийт 42.1 тэрбум төгрөгийг тарааж буй нь нийт цэвэр ашгийн ойролцоогоор 30%-тай тэнцэж байна. Энэхүү ногдол ашгийн хэмжээ нь Банкны түүхэн дэх хамгийн өндөр дүн бөгөөд санал болгож буй хэмжээ нь Үнэт цаасны танилцуулгын төлөвлөгөөтэй нийцэж байна. Хараат бус гишүүдийн зүгээс тус ногдол ашгийн хэмжээг тохиромжтой гэж үзэж, энэ саналыг дэмжсэн.

Хараат бус гишүүд бид банкинд компанийн сайн засаглалыг сахин хамгаалахад дэмжлэг үзүүлсээр ирсэн. Одоогоор, ТУЗ-ийн бүрэлдэхүүнд 3 Хараат бус гишүүн ажиллаж байна. Бүх хараат бус гишүүд нь ТУЗ-ийн дэргэдэх 3 Хороодын гишүүд бөгөөд хороо тус бүрийн 2/3-ыг бүрдүүлдэг. Уламбаяр миний бие, 2022 оноос хойш ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны даргаар ажиллаж байна. Энэ удаагийн банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтын үр дүнд, ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь хуулийн шаардлагыг хангасан нийт 4 хараат бус гишүүнтэй болно гэж итгэж байна.

Банкны засаглал, ашиг сонирхлын зөрчил болон хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувьд, ТУЗ болон удирдлагын хүрээнд ямар нэгэн ноцтой асуудал илрээгүй болохыг тэмдэглэж байна.

Өнгөрсөн жил ТУЗ-ийн хурлаар, олон улсын санхүүгийн байгууллагууд болох ЕСБХБ, ОУСК-тай байгуулах бодлогын гэрээ, хэлэлцээрийн талаар танилцаж хэлэлцсэн. Хараат бус гишүүдийн зүгээс, тус саналыг Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд оруулан хувьцаа эзэмшигчдээр эцэслэн шийдвэрлүүлэх ТУЗ-ийн дүгнэлтийг дэмжсэн.

Банкны тухай хуулийг дагаж мөрдөхийн тулд, Банк өөрийн толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг өөртөө нэгтгэх нь нэн чухал байна. Энэ асуудалд хувьцаа эзэмшигчдээс анхаарал хандуулж, цаг алдалгүй шийдвэрлэж өгөхийг хүсч байна.

Эцэст нь, Хараат бус гишүүдийн зүгээс ТУЗ-ийн бүх шийдвэртэй санал нийлж, дэмжсэн болохыг тэмдэглэж байна.”

Тайланг танилцуулсны дараагаар Хурлын даргын зарласнаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

9. ХАСБАНКНЫ 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ЦЭВЭР АШГААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ТУХАЙ

ТУЗ нь 2024 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн R-2024-02 дугаар тогтоолоороо Банкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хувьцаа эзэмшигчдэдээ зарлан хуваарилах зөвлөмжийг хүргүүлсэн болохыг Гүйцэтгэх захирал тэмдэглэв. Тэрээр Банкны Дүрэмд заасны дагуу энэхүү хувьцаа эзэмшигчдийн хурлаар ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж буйг тайлбарлав. Тус ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашигт нийт 26,580,675,000 төгрөг буюу нэгж хувьцаанд 25.25 төгрөг зарлан хуваарилахыг дэмжсэн байна.

Мөн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 09-ний өдөр байхаар санал болгосон байна.

Түүнчлэн Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомжид нийцүүлэн Монголбанкны 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн албан тоотор ХасБанкнаас ногдол ашиг хуваарилахад татгалзах зүйлгүй талаар албан хариу хүлээн авсан болохыг дурдав. Хэрэв хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тохиолдолд СЗХ-ны зохицуулалтын дагуу 4 дүгээр сарын 30-ны өдөр ногдол ашгийг Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д байршуулахыг онцлов.

Тэрээр ногдол ашиг олгох харьцаанд холбогдуулан, ХасБанк 2023 оны 1 дүгээр хагас жилийн цэвэр ашгаас 15.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан бөгөөд 2023 оны 2 дугаар хагас жилийн цэвэр ашгаас 26.6 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаар санал болгож буй талаар тайлбарлав. Ингэснээр 2023 оны санхүүгийн жилийн цэвэр ашгийн 30%-ийг ногдол ашиг хэлбэрээр тарааж, Үнэт цаасны танилцуулгад тусгасан зорилтыг биелүүлж байгааг онцоллоо. ХЭЭХ-ын тогтоолын төслийг урьдчилан хурлын материалд тусгасан болохыг тэмдэглэв. Гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийг асуулт асуухад урив.

Ийнхүү хурлын дэгийн дагуу, ТУЗ-ийн даргын зарласнаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ХЭЭХ-д цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигч Банк ногдол ашгийг хэрхэн тооцож олгодог болон ногдол ашиг тараалт банкны ашигт ажиллагаанд хамааралтай эсэх талаар тодруулав.

Гүйцэтгэх захирал дээрх асуултад дараах байдлаар хариулав. Тэрээр ногдол ашиг нь ашигт ажиллагаатай шууд хамааралтай болохыг дурдаад, ХасБанк 2023 онд 142 тэрбумын цэвэр ашигтай ажилласан тул Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-өөс ногдол ашиг тараах шийдвэрийг гаргасан. Ийнхүү ногдол ашиг хуваарилахдаа ирэх жилүүдийн банкны нийт салбар болон ерөнхий эдийн засгийн нөхцөл байдал, банкны ирээдүйн тогтвортой өсөлтийг хангахуйц өөрийн хөрөнгөтэй эсэх хоёр чухал үзүүлэлтийг тэнцвэржүүлэх байдлаар тооцоолон гаргадаг. Энэ жил ХасБанк цэвэр ашгийнхаа 30 хувьтай тэнцэх хэмжээний буюу Үнэт цаасны танилцуулгад тусгасан зорилтыг ханган шийдвэрлэсэн.

10. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭХ БҮРЭН ЭРХЭД ХОЛБОГДУУЛАН ХАСБАНКНЫ ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД Н.Мөнхцэлмэг ХасБанкны ХЭЭХ-д оролцож буй хувьцаа эзэмшигчдэдээ талархал илэрхийлээд, ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэмд оруулахаар санал болгож буй өөрчлөлтийн талаар танилцуулав.

Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр 49 дүгээр тогтоол гаргаж, 2020 оны 28 дугаар “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолдоо өөрчлөлт оруулан, нээлттэй хувьцаат компаниуд ногдол ашгаа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор тарааж дууссан байхыг үүрэг болгосон.

СЗХ-ноос баталсан шинэ зохицуулалтыг дагаж мөрдөн тогтоосон хугацаанд ногдол ашгийг тараахад, бусад хувьцаат компаниудаас ялгаатай нь ХасБанкны Дүрэм болон Ногдол ашгийн бодлогод зааснаар хувьцаа эзэмшигчдээс эцсийн зөвшөөрөл авах шаардлагатай байгаа нь практикт ихээхэн хүндрэл учруулж байна. Процессын хувьд, ТУЗ санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг шийдвэрлэдэг бөгөөд нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээг эцэслэн баталгаажуулах үндэслэл болсон аудитлагдсан санхүүгийн тайлан 3 дугаар сарын дундуур батлагддаг. Үүний дараагаар хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай шийдвэрийг ТУЗ гаргаж, түүнээс хуанлийн 40-өөс доошгүй хоногийн дараа буюу 4 дүгээр сарын сүүлд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралддаг болохыг тайлбарлав. Ийнхүү Дүрэмд заасны дагуу ХасБанкны ногдол ашиг хуваарилах эцсийн шийдвэр 4 дүгээр сарын сүүлийн долоо хоногуудад гарснаар ногдол ашгийн тараах ажиллагаа 4 дүгээр сарын 30-ны өдрөөс хойш хийгдэхээр байна. Иймд Гүйцэтгэх удирдлагын зүгээс Банкны Дүрэмд өөрчлөлт оруулж, ногдол ашиг зарлах, хуваарилах асуудлыг ТУЗ-ийн бүрэн эрхэд шилжүүлэх саналаа илэрхийлсэн бөгөөд үүнийг ХасБанкны ТУЗ 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-17 тоот тогтоолоороо дэмжсэн болно.

Иймээс СЗХ-ны шаардлагад нийцүүлэх үүднээс дараах байдлаар Банкны Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулж, 8 дугаар зүйлийн 8 (ii) дахь заалтыг хүчингүй болгохыг Хувьцаа эзэмшигчдэд санал болгов:

Одоогийн заалт	Өөрчлөлт оруулсан заалт
----------------	-------------------------



6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно. 8.6 Дор дурдсан асуудлыг энэхүү Дүрэмд заасан “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ. Стратегийн ач холбогдол бүхий асуудлын талаар аливаа шийдвэрийг гагцхүү ТУЗ-өөр хэлэлцсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна: (ii) ногдол ашиг тараах болон хуваарилах аливаа шийдвэр;	6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны <u>шийдвэрлэсний</u> үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно. 8.6 Дор дурдсан асуудлыг энэхүү Дүрэмд заасан “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ. Стратегийн ач холбогдол бүхий асуудлын талаар аливаа шийдвэрийг гагцхүү ТУЗ-өөр хэлэлцсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна: (ii) ногдол ашиг тараах болон хуваарилах аливаа шийдвэр;
---	--

11. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭХ БҮРЭН ЭРХЭД ХОЛБОГДУУЛАН ХАСБАНКНЫ НОГДОЛ АШГИЙН БОДЛОГОД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД үргэлжлүүлэн СЗХ-ны шаардлагад нийцүүлэн ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгов. Энэхүү нэмэлт өөрчлөлтөөр ногдол ашиг зарлах, хуваарилах асуудлыг ТУЗ-ийн бүрэн эрхэд шилжүүлэх бөгөөд үүнийг ХасБанкны ТУЗ 2024 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн R-2024-18 тоот тогтоолоор дэмжсэн болно.

Дараах байдлаар ХасБанкны Ногдол ашгийн бодлогын 3.2 дох хэсэгт өөрчлөлт оруулах, 3.3 болон 4.1 дэх хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулахыг санал болгон танилцуулав:

Одоогийн заалт	Өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт оруулсан заалт
3.2. Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг	3.2. Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг <u>Хувьцаа</u>

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. 3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй. 4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ.	эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ. 3.3. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн <u>шийдвэрлэснээр шийдвэрлэж</u>, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй. 4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж</u>, хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ <u>шийдвэрлэнэ</u>.
--	--

ХХЗ/ТУЗНБД дээрх 2 асуудлаар санал болгож буй нэмэлт өөрчлөлт нь гагцхүү ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг эцэслэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан гаргасан өөрчлөлт болохыг дахин онцоллоо.

ХХЗ/ТУЗНБД-ын урьснаар хурлын дэгийн дагуу, ХасБанкны Дүрэм болон Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай 4 болон 5 дугаар шийдвэрлэх асуудлуудаар хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг эхлэв.

ТУЗ-ийн дарга асуулт асуухыг дахин зарласан боловч хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

12. ФРЕЙМВОРК ГЭРЭЭ

Гүйцэтгэх захирал ХасБанк үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг явуулах, нийгмийн гол асуудлыг шийдвэрлэхийг эрхэмлэн ажиллаж буйг дурдаад, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (“ЕСБХБ”)-тай байгуулахаар санал болгож буй Фреймворк гэрээ нь агуулгын хувьд өнөөдөр ХасБанкны хүчин төгөлдөр мөрдөж буй бодлого, журмуудыг тусгасан гэрээ болохыг танилцуулав. Мөн энэхүү гэрээгээр Парисын хэлэлцээрт тусгасны дагуу хүлэмжийн хийг бууруулахтай холбоотой олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагааг банк ирээдүйд нэвтрүүлэх талаар тусгасан болно. Гэрээг бүрэн эхээр нь хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төслийн хамт ХЭЭХ-ын материалд тусгасан болохыг онцлон тэмдэглэв.

Танилцуулгын дараагаар хурлын дэгийн дагуу, Гүйцэтгэх захирал хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цаг нээснийг мэдэгдэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул ТУЗ-ийн дарга хэсэг хугацаанд хүлээгээд хэлэлцэх дараагийн асуудалд оров.

13. БОДЛОГЫН ГЭРЭЭ

Гүйцэтгэх захирал Олон Улсын Санхүүгийн Корпораци (“ОУСК”)-тай байгуулахаар санал болгож буй Бодлогын гэрээ нь агуулгын хувьд Фреймворк гэрээтэй ижил төстэй, ХасБанкны хүчин төгөлдөр мөрдөж буй бодлого, журмуудыг тусгасан гэрээ болохыг тайлбарлав. Үүнд ХасБанк хүлэмжийн хийг бууруулах болон нийгэм хамгааллын хүрээнд хүлээх үүрэг бүхий холбогдох заалтуудыг тусгасан бөгөөд хувьцаа

ХАСБанкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэл
эзэмшигчдэд энэхүү гэрээний төслийг ХЭЭХ-ын материалд тусгах замаар урьдчилан
танилцуулсан болохыг онцлов.

Танилцуулгын дараагаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт
асууж, хариулт авах цаг эхлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэлэлцэх дараагийн асуудалд оров.

14. НЭГТГЭХ ЗАМААР ХАСБАНКИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Гүйцэтгэх захирал Банкны тухай хуулийн 36.1 дэх хэсэгт заасны дагуу аль нэг хувьцаа
эзэмшигч дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцааны хэмжээ нь
банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг ХасБанкны нийт
гаргасан хувьцааны 94.99%-ийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн
Нэгдэл ХХК ("ТСН")-ийг ХасБанкинд нэгтгэх замаар хангахаар, өөрчлөн байгуулалтын
асуудлыг энэ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж байгаа талаар
хувьцаа эзэмшигчдэд тайлбарлав.

Тэрээр 2021 оны 1 дүгээр сард батлагдсан Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг
дагаж мөрдөх зорилгоор, энэхүү өөрчлөн байгуулалтын ажлын хүрээнд ТСН-д хийсэн
бүтцийн өөрчлөлтийг тоймлон хүргээд, 2024 оны 3 дугаар сарын байдлаарх компанийн
бүтцийг дэлгэрэнгүй танилцуулав. Мөн тус хууль батлагдахаас өмнө ХасБанк эцсийн
өмчлөгчийн хувьд 20 хувийн шаардлагыг аль хэдийн хангасан байсныг онцлоод, энэхүү
бүтцийн өөрчлөлтөөр ТСН үйл ажиллагаагаа зогсоон, ХасБанк үйл ажиллагаагаа
үргэлжлүүлэн үлдэж, үр дүнд нь ТСН-ийн хувьцаа эзэмшигчид ХасБанкны шууд хувьцаа
эзэмшигч болохыг тайлбарлав.

Гүйцэтгэх захирал нэгтгэх өөрчлөн байгуулалтыг саадгүй хийхэд шаардагдах
зөвшөөрлүүдийн талаар тайлбарлаад, ТСН-ийн санхүүгийн хураангуй тэнцлийг 2023
оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар танилцуулав.

ТСН-ийн хувьцааг ХасБанкны хувьцаанд хөрвүүлэх хөрвүүлэлтийн харьцааг
хөндлөнгийн татварын болон хуулийн компанийн зөвлөмжийн дагуу тооцохдоо ТСН-ийн
эзэмшиж буй ХасБанкны нийт хувьцааны тоо болох 1,000,000,000 ширхэг хувьцааг
ТСН-ийн одоогийн 10 хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй нийт хувьцаа болох
16,270,503 ширхэг хувьцаанд хувааж, хөрвүүлэлтийн харьцаа 61.46091488 болсон.
Ийнхүү ТСН-ийн 10 хувьцаа эзэмшигч дээрх харьцаагаар ТСН-д эзэмшиж буй
хувьцаагаа ХасБанкны хувьцаанд хөрвүүлэн, ХасБанкны шууд хувьцаа эзэмшигч болно.

Тэрээр үргэлжлүүлэн нэгтгэлийн дараа ХасБанкны бизнесийн үйл ажиллагаанд
ямарваа нэгэн өөрчлөлт гарахгүй талаар тайлбарлаад Компанийн тухай хуулийн 53.1.1
дэх хэсэгт заасны дагуу нэгтгэх замаар компанийг өөрчлөн байгуулахад эсрэг саналтай
байсан, эсхүл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч хувьцааг эргүүлэн
худалдан авахыг компаниас шаардах эрхтэй талаар танилцуулав.

Гүйцэтгэх захирал нэгтгэх өөрчлөн байгуулалтын талаарх дэлгэрэнгүй материалууд
буюу хуулийн дүгнэлтийн хураангуй, ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх зөвлөмж хүргүүлэх
тухай ТУЗ-ийн 2024 оны 3 сарын 07-ны өдрийн тогтоол, ТСН болон ХасБанкны хооронд
байгуулах Нэгтгэх гэрээний төсөл, Нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах нөхцөл,
журам зэргийг хувьцаа эзэмшигчдэд урьдчилан тараасан болохыг онцлов.

Танилцуулгын дараагаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт
асууж, хариулт авах цаг ТУЗ-ийн даргын зарласнаар эхлэв. Хурлын дарга нэгтгэлтэй

ХАСБанкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэл холбоотой бүхий л ажиллагаанд оролцож дүгнэлт гаргасан хөндлөнгийн зөвлөх компаниуд мөн хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулахаар хүрэлцэн ирсэн болохыг дурдав.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

15. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРАЛ ХҮРТЭЛ ХУГАЦААНД БҮРЭН ЭРХ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД хурлын дараагийн хэлэлцэх асуудлаар, ХасБанк нээлттэй хувьцаат компани болсноос хойш ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг анх удаа зохион байгуулж буй талаар тэмдэглэв. Компанийн тухай хуулийн 77.4 дэх хэсэгт зааснаар хувьцаат компанийн ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар, бүрэн бүрэлдэхүүнээр нь сонгоно. Мөн Банкны Дүрмийн 8.16 дахь хэсэгт заасны дагуу ТУЗ-ийн бүрэн эрх 2 (хоёр) жилийн хугацаатай учир 2024 оны ХЭЭХ-аар сонгогдсон ТУЗ нь бүрэн эрхээ 2026 оны ХЭЭХ хүртэл хэрэгжүүлнэ. Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (“ЗНДЦУХ”) Банкны ТУЗ-ийн 12 гишүүний орон тоонд 14 нэр дэвшигчдийг дэвшүүлснээс Монголбанк 13 хүнийг нэр дэвшүүлэхэд татгалзах зүйлгүйгээ мэдэгдэж холбогдох хариуг ирүүлсэн.

Нэр дэвшигчдийн бүтцийн хувьд, энгийн гишүүнд ТСН-ийн томоохон хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл 6 нэр дэвшигч, Банкны Дүрэмд заасны дагуу гүйцэтгэх удирдлагын төлөөлөл 1 нэр дэвшигч, хувьцаа эзэмшигчдээс хамааралгүй 1 нэр дэвшигч, хараат бус гишүүнд 5 нэр дэвшигчийг дэвшүүлж буй талаар тэмдэглэв. Тэрээр ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу ТСН-ийн хувьцааны 10%-иас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь ТСН-ийн томоохон хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл энгийн гишүүнд нэр дэвшүүлдэг болохыг тайлбарлаад дараах байдлаар Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнээс бусад гишүүнд нэр дэвшигчдийн талаар танилцуулав:

#	Нэр	Нэр дэвшиж буй албан тушаал	ТУЗ-д ажилласан жил	Томоохон хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл эсэх
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн гишүүн	7 жил	Хамааралгүй
2	Албертус Браггинк	ТУЗ-ийн гишүүн	3 жил	Орикс корпораци
3	Анджей Витак	ТУЗ-ийн гишүүн	5 жил	ЕСБХБ
4	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	15 жил	Ронкок партнерз
5	Сюзанна Херринг Карр	ТУЗ-ийн гишүүн	2 жил	ОУСК
6	Нямтайширын Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	11 жил	МАК Инвест ХХК
7	Гүмэнжавын Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	4 жил	Гүйцэтгэх удирдлагаас
8	Доминик Жак	ТУЗ-ийн гишүүн	Шинэ нэр дэвшигч	Канадын үндэсний банк

ХХЗ/ТУЗНБД үргэлжлүүлэн Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн талаар танилцуулав:

#	Нэр	Нэр дэвшиж буй албан тушаал	ТУЗ-д ажилласан жил
1	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	5 жил
2	Баянсаны Уламбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	9 жил
3	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	1 жил
4	Лоуренс Цонг	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Шинэ нэр дэвшигч

5	Стюард Доналд Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Шинэ нэр дэвшигч
---	--------------------	---------------------------	------------------

Танилцуулгаа дуусгаад ХХЗ/ТУЗНБД хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цагийг нээж асуулт асуухыг урив.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул ТУЗ-ийн дарга хэсэг хугацааны дараа хэлэлцэх дараагийн асуудалд оров.

16. ТУЗ-ИЙН ГИШҮҮНИЙ ЦАЛИН УРАМШУУЛЛЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД хүчин төгөлдөр үйлчилж буй Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын дагуу ТУЗ-ийн гишүүдэд жилд 45,0 мянган ам.доллартай тэнцэх хэмжээний хөлсийг төгрөгөөр, нэг болон түүнээс дээш тооны хороод даргалж буй бол 5,0 мянган ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгийн нэмэгдлийг олгож буй талаар тайлбарлав.

Банктай харьцуулах боломжтой компаниудын ТУЗ-ийн гишүүдэд санал болгож буй цалин урамшууллын багцын талаар нарийвчилсан дүн шинжилгээг хөндлөнгийн хүний нөөцийн зөвлөгөө өгөх байгууллагаар хийлгэсний үндсэн дээр ЗНДЦУХ нь ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоохыг санал болгосон. Тус саналд ТУЗ-ийн гишүүдэд жилд олгох нийт хөлсийг 50,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоох буюу өмнө тогтоосон хэмжээг 5,000 ам.доллараар нэмэгдүүлэн тогтоохыг санал болгосон бол нэг болон түүнээс дээш тооны хороод даргалж буй гишүүнд жилд олгох нэмэгдлийн хэмжээг 5,000 ам.доллартай тэнцэх хэмжээний төгрөгөөр хэвээр тогтоохоор санал болгосныг онцлов.

Түүнчлэн уг саналыг ТУЗ хэлэлцээд R-2024-10 дугаар тогтоолоороо дэмжин, хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцүүлэхээр оруулсан болохыг дурдав.

ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох асуудлаар хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цагийг ТУЗ-ийн дарга эхлүүлэв.

Хувьцаа эзэмшигчид асуулт асуугаагүй тул хэсэг хугацаанд хүлээгээд хэлэлцэх дараагийн асуудалд оров.

17. ТУЗ-ИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙГ БАТЛАХ ТУХАЙ

ХХЗ/ТУЗНБД ХасБанкны Дүрмийн 8.6 (v) дахь заалтад зааснаар ТУЗ-ийн төсөв тогтоох нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэрлэх асуудал тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлүүлэхээр ХасБанкны ТУЗ-өөс 2024 оны төсвийг 6,7 тэрбум төгрөгийн дүнтэйгээр оруулсан болохыг тайлбарлав.

ТУЗ-ийн төсөв 2023 онд 5.9 тэрбум төгрөгөөр батлагдаж байсан бөгөөд бодит гүйцэтгэл мөн 5.9 тэрбум төгрөг байсан болохыг тэмдэглэв.

Тэрээр цаашлаад ТУЗ-ийн 2024 оны өмнөх оноос 14%-иар нэмэгдүүлэн төсөвлөсөн болохыг дурдаад, төсөвт (i) хөлс, нэмэгдэл, урамшуулал (үүнд ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн хөлс, нэмэгдэл, урамшуулал багтах ба гүйцэтгэх захирал ТУЗ-ийн гишүүнээр ажилласныхаа төлөө аливаа, хөлс, нэмэгдэл, урамшуулал авдаггүй), (ii) бусад зардал (татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, зорчих болон буудаллах зардал, хурал зохион байгуулах зардал, ТУЗ-д үйлчилгээ үзүүлэх хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээний төлбөр зэрэг) багтдаг болохыг дурдав.

Танилцуулгын дараа хурлын дэгийн дагуу, хувьцаа эзэмшигчдийн зүгээс асуулт асууж, хариулт авах цагийг ТУЗ-ийн дарга эхлүүлэв.

Тухайн хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт асуугаагүй бөгөөд харин ХЭЭХ-д цахимаар оролцож буй хувьцаа эзэмшигчид хурлын үеэр өмнө хэлэлцсэн асуудлуудтай холбоотой асуусан дараах асуултуудыг Гүйцэтгэх захирал танилцуулав:

1. Ногдол ашгийг жилээр болон хагас жилээр олгохын ялгаа;
2. ТСН-ийг ХасБанкинд нэгтгэснээр ХасБанкны хувьцааны үнэ, ногдол ашгийн хэмжээнд ямар нэгэн өөрчлөлт гарах эсэх;
3. Банкны 2024 оны цэвэр ашгийн төлөвлөгөө болоод 2024 оны I улирлын тайлангийн гүйцэтгэлийн талаар.

Гүйцэтгэх захирал дээрх асуултад дараах байдлаар хариулав:

1. Ногдол ашгийг жилд хоёр удаа хуваарилснаар хувьцаа эзэмшигч нь өөрийн хөрөнгө оруулалтын өгөөжийг жилд хоёр удаа авах боломжтой болж байгаа. Мөн ХасБанк нь системд нөлөө бүхий банкууд дундаас ногдол ашгийг жилд хоёр удаа хуваарилсан анхны банк болсныг онцлоод, олон улсын жишгийн хүрээнд томоохон компаниуд ногдол ашгийг жилд дор хаяж хоёр удаа тараадгийн дагуу Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ ийнхүү шийдвэрлэсэн.
2. ТСН-ийг ХасБанкинд нэгтгэснээр ХасБанкны хувьцааны 94.99%-ийн төвлөрөл задарна. Энэхүү нэгтгэл нь хувьцааны үнэд хэрхэн нөлөөлөх талаар байр суурь илэрхийлэх боломжгүй байна. Хөрөнгийн зах зээл нь эрэлт, нийлүүлэлтийн хуульд суурилсан байдаг тул хувьцааны үнэ өсөх, буурахыг тааварлашгүй. Гэхдээ олон улсын жишгээс харахад, төвлөрөл задарч буй мэдэгдэл нь хувьцааны үнэд эерэг нөлөөтэй байдаг туршлага бий. Харин 2023 оны цэвэр ашгаас хуваарилсан ногдол ашгийн хэмжээнд ямарваа нэгэн нөлөө байхгүй.
3. 2024 оны I улирлын гүйцэтгэлийг нийтэд өөрийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан танилцуулсан бөгөөд ХасБанк I улиралд 42 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, өөрийн хөрөнгийн өгөөж 26 хувьтай, төсвийн гүйцэтгэлийг давуулан биелүүлсэн байна.

18. САНАЛ ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

Танилцуулгуудын дараа, Гүйцэтгэх захирал ХасMeeting аппликейшнийг хэрэглэх заавар болон санал хураах аргын талаар товч танилцуулав.

Тэрээр үргэлжлүүлэн 10 асуудалд ердийн санал өгөх журмаар санал өгөх бол ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай асуудалд кумулятив аргаар санал өгөх журмаар саналаа өгөх шаардлагатайг хувьцаа эзэмшигчдэд тайлбарлав.

Үүний дараа, Хурлын дарга шийдвэрлэх 11 асуудлуудаар санал хураалтыг эхлүүлэв. Тэрээр дэлгэц дээр эхлүүлсэн 20 минут тоолж дуусмагц бүх санал хураалт нэгэн зэрэг дуусгавар болохыг сануулаад хувьцаа эзэмшигчдийг санал хураалтдаа оролцохыг уриалж тэдгээрийн санал үнэ цэнтэй болохыг тэмдэглэв.

ХАСБанкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэл
Санал хураалтын цаг дуусч санал хураалт хаагдсаны дараа хурлын дэгийн дагуу завсарлага авч, тооллогын комисс санал хураалтын дүнг нэгтгэх ажлыг эхлүүлэв.

19. САНАЛ ХУРААЛТЫН ҮР ДҮН: ШИЙДВЭР

Тооллогын комиссын дарга Б.Ананд хувьцаа эзэмшигчдээр батлуулахаар санал болгосон асуудал тус бүрийн санал хураалтын үр дүнг танилцуулав.

Санал хураалт #1: ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,010,392,953	99,95%
Татгалзсан	-	-
Түдгэлзсэн	527,308	0,05%

Шийдвэр #1:

ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.95% (ерэн ес зууны ерэн тав) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #2: ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай

ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,010,398,358	99,95%
Татгалзсан	-	-
Түдгэлзсэн	521,903	0,05%

Шийдвэр #2:

ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч

ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хурлын тэмдэглэл
оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.95% (ерэн ес зууны ерэн тав) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #3: ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай

ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,813,154	99,89%
Татгалзсан	63,411	0,01%
Түдгэлзсэн	1,043,696	0,10%

Шийдвэр #3:

ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.89% (ерэн ес зууны наян ес) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #4: ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай

ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	10,192,375	1,01%
Татгалзсан	1,000,205,983	98,94%
Түдгэлзсэн	521,903	0,05%

Шийдвэр #4:

ХасБанкны Дүрэмд өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 98.94% (ерэн найм зууны ерэн дөрөв) хувийн Хувьцаа эзэмшигчдийн татгалзсан саналаар БАТЛАГДСАНГҮЙ.

Санал хураалт #5: ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай

ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,010,040,927	99,91%
Татгалзсан	235,006	0,02%
Түдгэлзсэн	644,328	0,06%

Шийдвэр #5:

ХасБанкны Ногдол ашгийн бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.91% (ерэн ес зууны ерэн нэг) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #6: ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай

ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,008,253,979	99,74%
Татгалзсан	1,284,848	0,13%
Түдгэлзсэн	1,381,434	0,14%

Шийдвэр #6:

ХасБанк болон ЕСБХБ нарын хооронд Фреймворк гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Фреймворк гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.74% (ерэн ес зууны далан дөрөв) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #7: ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай

ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,008,284,216	99,74%
Татгалзсан	1,284,848	0,13%
Түдгэлзсэн	1,351,197	0,13%

Шийдвэр #7:

ХасБанк болон ОУСК нарын хооронд Бодлогын гэрээ байгуулахыг зөвшөөрч, Гүйцэтгэх захиралд Бодлогын гэрээнд гарын үсэг зурахыг даалгах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.74% (ерэн ес зууны далан дөрөв) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #8: ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,010,260,236	99,94%
Татгалзсан	98,563	0,01%
Түдгэлзсэн	561,462	0,06%

Шийдвэр #8:

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх хэлбэрээр ХасБанкийг өөрчлөн байгуулах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.94% (ерэн ес зууны ерэн дөрөв) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #9: Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

Хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар ТУЗ-д нэр дэвшигчдэд кумулятив санал өгөв:

#	ТУЗ-д нэр дэвшигчдийн нэр	Дэмжсэн кумулятив саналын тоо
ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад гишүүнд нэр дэвшигчид		
1	Нямтайширын Цэлмүүн	1,007,774,279
2	Сюзанна Херринг Карр	1,002,544,894
3	Албертус Браггинк	1,003,306,863
4	Анджей Витак	1,001,359,268
5	Доминик Жак	1,002,588,813
6	Майкл Мадден	1,007,437,761
7	Санжай Гүпта	1,021,355,728
8	Гүмэнжавын Цэвэгжав	1,031,022,552
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид		
1	Баянсаны Уламбаяр	1,009,923,468
2	Нираж Вэдва	1,001,253,414
3	Эми Чой	1,001,280,347
4	Лоуренс Цонг	2,566,127
5	Стюарт Доналд Холл	1,002,140,514

Шийдвэр #9:

Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдэд дараах нэр дэвшигчид хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн дэмжсэн саналаар сонгогдов:

ТУЗ-ийн хараат бус гишүүнээс бусад гишүүнд:

1. Гүмэнжавын Цэвэгжав;
2. Санжай Гүпта;
3. Нямтайширын Цэлмүүн;
4. Майкл Мадден;
5. Албертус Браггинк;
6. Доминик Жак;
7. Сюзанна Херринг Карр; мөн
8. Анжей Витак.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд:

1. Баянсаны Уламбаяр;
2. Стюарт Доналд Холл;
3. Эми Чой; мөн
4. Нираж Вэдва.

Санал хураалт #10: ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай

ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

**ХАСБАНК**

ХАСБАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,008,862,643	99,80%
Татгалзсан	333,578	0,03%
Түдгэлзсэн	1,724,040	0,17%

Шийдвэр #10:

ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.80% (өрөн өс зууны ная) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

Санал хураалт #11: ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай

ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай асуудлаар санал хураалтын дүнг танилцуулав.

ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай тогтоолыг батлах эсэх асуудлаар хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид дараах байдлаар санал өгөв:

	Хувьцааны тоо	Хувь
Зөвшөөрсөн	1,009,476,303	99,86%
Татгалзсан	289,881	0,03%
Түдгэлзсэн	1,154,077	0,11%

Шийдвэр #11:

ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах тухай тогтоолын төсөл хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн, итгэмжлэн төлөөлөгчөөр, цахим хэлбэрээр болон урьдчилан санал өгч оролцож буй Хувьцаа эзэмшигчдийн 99.86% (өрөн өс зууны наян зургаа) хувийн Хувьцаа эзэмшигчдийн зөвшөөрсөн саналаар батлагдав.

ХУРЛЫН ХААЛТ

Хурлын дарга ХЭЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлээд хурлыг албан ёсоор хаав.

Гарын үсэг зурсан:

Санжай Гүпта

Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын дарга

Гарын үсэг зурсан:

Н.Мөнхцэлмэг

Хууль хариуцсан захирал бөгөөд
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга